



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БИНДЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/99

Биндэр сум

**Ойд явуулах үйл ажиллагааны хориг
цуцлах, захирамж хүчингүй болгох тухай**

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.14 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын нийт нутгаар бороо орж хуурайшилтын зэрэг буурч байгаа тул ой, хээрийн бүсэд аялал зугаалга хийх, нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах, ойгоос мод бэлтгэх, тээвэрлэх, эмчилгээ сувилгаа эрхлэх үйл ажиллагааг явуулахыг түр хориглосон шийдвэрийг 2026 оны 06 дугаар сарын 11-ны өдрөөс эхлэн цуцалсугай.

2.Дээрх шийдвэрийг аж ахуй нэгж байгууллага, нөхөрлөлийн дарга, иргэдэд мэдээлэхийг Биндэр-Ой сум дундын Ойн ангийн дарга (О.Сүхбат), Байгаль хамгаалагч (Н.Болор-Эрдэнэ), Багийн засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2026 оны 04 дүгээр сарын 20-ний А/62 захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ДЭМБЭРЭЛСАЙХАН